

**Монгол хэлний нутгийн аялгууны үгсийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс
судлах нь**
(Өөлд аман аялгууны жишээгээр)

Түмэн-Очирын Эрдэнэсүрэн 

Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын Дээд Сургуулийн магистрант

Хөх хот, Хятад

Хүлээн авсан - Received:
2023-12-15

Засварласан - Revised:
2023-12-20

Хэвлэгдсэн - Published:
2023-12-26

erdenesurentu@gmail.com

ORCID: [0009-0005-0189-2084](https://orcid.org/0009-0005-0189-2084)



© 2023, Author(s)

Хураангуй: Монгол Улсад тархан суурьшсан өөлд угсаатнууд дундаас ойрад аялгууныхаа аман ярианы өвөрмөц үгсийг хэвээр хадгалан буй Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, халхуудтай хил залган амьдарч буй Архангай аймгийн Өлзийт, Өгийнуур сумын халхажсан өөлдүүд болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр хотын Эвенк Үндэстний Өөртөө Засах Хошууны Имин сумын Баянтал, Агуйт, Имин, Билүүт гэх дөрвөн гацаанд голлон тархан суурьшсан өөлд угсаатнуудын өвөрмөц онцлогтой үгсийг түүвэрлэн авч нийгэм хэл шинжлэлийн аргаар судлав. Дээр дурдсан өөлдүүд харилцан адилгүй газар оронд амьдарч байгаа, нийгмийн давхарга, аж амьдралын хүрээ цараа, нийгэмд эрхэлж буй ажил, албан тушаал, нас, хүйс, харилцаж байгаа этгээд гэх мэт нийгмийн байдлаас шалтгаалан өвөрмөц онцлогтой үгсийн хэрэглээ өөр хоорондоо адилгүй байна.

Түлхүүр үг: Өөлд аман аялгууны үгс, Ойрад аман аялгуу, өвөрмөц онцлогтой үгс

Удиртгал

Үг бол аливаа хэлний үндсэн нэгж мөн. Хэлний үгсийн бүрэлдэхүүн бол тухайн хэлний бүрэлдэхүүн ямар байгааг тусган үзүүлдэг бөгөөд хэдий хэр баялаг байна төдий чинээ баялаг хөгжсөн болохыг илтгэн өгүүлэх хэмжүүр болдог. Аливаа үндэстэн, угсаатны хэл нь хөдлөнгө хийгээд зогсонги шинж чанартай болохынхоо хувьд үгсийн сангийн нэг хэсэг нь нийгэм, соёлын харилцан нөлөөллөөс үүдэлтэйгээр хэрэглээний хувьд идэвхгүй болж хуучирч байхад, мөн нөгөө хэсэг үг хэрэглээнд шинээр нэвтрэн орж ирдэг нь хэлний “зүй тогтолт хууль” юм.

Монгол Улсад тархан суурьшсан өөлд угсаатнууд дундаас ойрад аялгууныхаа аман ярианы өвөрмөц үгсийг хэвээр хадгалан буй Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум,

халхуудтай хил залган амьдарч буй Архангай аймгийн Өлзийт, Өгийнуур сумын халхажсан өөлдүүд болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр хотын Эвенк Үндэстний Өөртөө Засах Хошууны Имин сумын Баянтал, Агуйт, Имин, Билүүт гэх дөрвөн гацаанд голлон тархан суурьшсан Өөлд угсаатнуудын өвөрмөц онцлогтой үгсийг түүвэрлэн авч нийгэм хэл шинжлэлийн аргаар судаллаа. Бидний судалгаанд хамрагдаж буй өөлдүүд харилцан адилгүй газар оронд амьдарч байгаа, нийгмийн давхарга, аж амьдралын хүрээ цараа, нийгэмд эрхэлж буй ажил албан тушаал, нас, хүйс, харилцаж байгаа этгээд гэх мэт нийгмийн байдлаас шалтгаалан өвөрмөц онцлогтой үгсийн хэрэглээ өөр хоорондоо адилгүй байна. Мөн бид энэхүү судалгаандаа эрдэмтэн Д.Бадамдорж, С.Баттулга нарын бичсэн тайлбар толиудаас халх аман аялгуунд хэрэглэгддэггүй 100 үгийг түүвэрлэн авч, тэдгээр үгийг дээрх газруудад амьдарч буй Өөлд угсаатнууд өнөөгийн байдалд хэрхэн хэрэглэж байгаа болоод тухайн газар оронд амьдарч буй хүмүүс сонгосон үгсээс хэр их үгийг мэдэж байгааг харьцуулан судлав. Мөн түүвэрлэн авсан үгсээ зүйлчлэн хуваагаад газар орон бүрийн өвөрмөц онцлог бүхий үгсийн жагсаалтыг гаргав.

1.1. Судалгааны арга зүй

Бид энэхүү судалгаандаа нийгэм хэл шинжлэлийн аргууд болох материал цуглуулах арга, анкетын арга, ярилцлагын арга, хээрийн шинжилгээ хийх буюу задлах арга, харьцуулж задлах, тоо бүртгэлийн аргуудыг ашигласан болно.

1.2. Өөлд аман аялгууны судлагдсан байдал

Монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов *Монгол бичгийн хэл ба халх аялгууны харьцуулсан хэл зүй* хэмээх бүтээлдээ монгол хэл аялгууг баруун, зүүн салаа хэмээн хуваасан бөгөөд баруун хэсгийн өмнөд хэсэгт Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өөлдүүдийг багтаажээ. Мөн тус бүтээлдээ “... Дамбий-Өөлд аман аялгуу” гэж нэрийдэн хэсэг үгсийг авч монгол бичгийн хэл, халх болон бусад аялгууны үгстэй харьцуулан тэмдэглэжээ. Дамбий-Өөлд гэдэг нь халхын дундах Орхон голын өөлдөөс тасран уугуул нутаг руугаа буцаж нүүсэн одоогийн Цамбагарав уулын өөлдүүд юм. Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум бол өөлд аман яриа, өвөрмөц онцлогтой үгсийн сан, өв соёл, ёс заншлаа хадгалсаар байгаа өөлдүүд юм. Энэ суманд одоогоор 682 өрх, 2341 хүн ам амьдардаг бөгөөд хүн амын 89% нь Өөлдүүд, 11% нь Казак, Мянгад болон бусад ястнаас бүрдсэн газар юм.⁵

Эрдэнэбүрэн сумын өөлд аман аялгуу болон өөлд угсаатнуудын талаар судалгааг тусгайлан судалсан Д.Бадамдорж, С.Баттулга нар *Өөлд аман аялгууны ойллого* хэмээх ганц сэдэвт зохиол бичиж, өөлд аялгууны авиа зүй, үг зүй буюу хэлбэр

⁵ Үндэсний статистикийн хороо, 2023: <https://nso.mn/mn>

судлал, үгийн сангийн онцлогдох шинжийг товчоолон бичиж, биеэ даасан аман аялгуу мөн болохыг баримтаар нотолж өөлдийн аман аялгууны товч толийг хавсарган нийтлүүлжээ. Гэвч энэхүү бүтээлдээ Архангай аймгийн өөлдүүд болон Хөлөнбуйрын өөлд угсаатнуудын талаар дурдсан зүйл үгүй байна.

Мөн судлаач С.Баттулга *Өөлдийн аман аялгуу* хэмээх бүтээлдээ өөлд аман аялгууны авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүйг нарийвчлан судалж, өөлд аман аялгуутны оршин суудаг газар орноор биечлэн судалгаа хийж түүнийгээ нарийвчлан эмхэтгэн гаргасан төдийгүй түүхийн янз бүрийн шалтгаанаар бие биеэсээ алс ангид суух болсон ч түүх, хэл аялгууныхаа хувьд онцлох үүрэгтэй явж ирсэн Өөлд аман аялгууны талаар нэлээд судалжээ. Үүгээр зогсохгүй Өөлд аман аялгууны товч тайлбар толийг дагалдуулан хэвлүүлсэн байна. Бид энэхүү судалгаандаа дээрх хоёр толийг судалгааныхаа гол хэрэглэгдэхүүн болгон сонгон ашигласан болно.

Эрдэмтэн Ж.Санжаа (2004) “Архангай аймгийн халхажсан өөлдийн аман аялгуу” хэмээх өгүүлэлдээ өөлд аман аялгууны авиа зүй, хэл зүй болон үгийн сангийн онцлогийг гарган тайлбарлажээ. Тэрээр тус өгүүлэлдээ “...Үгсийн сангийн хувьд цөөвтөр боловч ойрад нутгийн аялгуудын нийтлэг үгс болон өөлдийн аман аялгууны өвөрмөц онцлогтой үгсийг хадгалан эдүгээ өөр зуураа ярилцсаар байна” гэсэн саналыг бид баримжаа болгон магадлах үүднээс Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуур сумдад хээрийн шинжилгээ хийж, өөлд аман аялгууны өвөрмөц онцлогийг тусгасан үг сангийн бүрэлдэхүүнийг гаргасан болно.

Мөн бид энэхүү судалгааныхаа цар хүрээг нэмэгдүүлж, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр хотын Эвенк Үндэстний Өөртөө Засах Хошууны Барга, Буриадудтай хөршилж, Эвенк үндэстэнтэй ихээр холилдон суурьшсан Имин сумын Имин, Билүүт, Агуйт, Баянтал зэрэг гацаадад голлон амьдардаг Өөлдүүдийг судалгаандаа хамруулан авч үзэв.

Хөлөнбуйрын өөлдүүд бол 1732 онд мөн 1757 онд уугуул нутаг Алтайгаас халх, цахар зэрэг олон нутгийг дамжин, Хөлөнбуйрын Имин голын дагуу нүүдэллэж очсон Ойрадууд юм.

Эрдэмтэн П.Гэрэлт (2009) “Хуучин болон шинэ өөлдүүд нийлээд Хөлөнбуйрт 1864-1990 онд 360 өрх буюу нийтдээ 1594 хүн нүүж очсон гэх тоо баримт гаргасан. Гэвч энэ тоон дахь шинэ өөлд угсаатнуудын дотор дөрвөд, галзад, мянгадаас өөр өрх ба хүний тоо ороогүйгээс үзэхэд “2000 илүү хүн байсан хэмээх яриа нэлээд бодитой” гэжээ. Өдгөө өөлд угсаатнуудын нийгэм түүхийн эрээнтэй бараантай он жилүүдийн уртад Хөлөнбуйрын өөлд угсаатнуудын газар нутаг хумигдаж, хүн ам ч цөөрсөөр ойр орчмын хэл аялгуу ба баримжаа авианы давхар нөлөөг ихээр тусгаж, Өөлд угсаатнуудын ярианы хэлэн дэх уугуул аман аялгууных нь хэрэглээ, цар хүрээ нь аажим аажмаар багассаар иржээ.

Гэвч Хөлөнбуйрын өөлд угсаатнуудын үгийн сан тэр чигтээ өөр аялгуунд уусан шингээгүй юм. Эдгээр өөлдүүд онцлогдон ялгагдах үгсийн сангийн өвөрмөц байдал, хэл яриан дахь утга, бүтэц, хэлбэрийн хувьд өвөрмөц онцлог бүхий үгсээ зохих хэмжээгээр хадгалсаар байгаа бөгөөд ойрад аялгууны үгс ч маш их байна.

Хөлөнбуйрын хэл аялгууны өвөрмөц онцлогтой үгсийн талаар эрдэмтэн судлаач Урьхан, профессор Бадма-Одсэр нарын 2020 онд бичсэн “Хөлөнбуйрын өөлд Монголчуудын хэл яриан дахь өвөрмөц үгс” хэмээх өгүүллийг эс тооцвол, Хөлөнбуйрын өвөрмөц онцлог бүхий үгсийн судалгаа тусгайлан хийгдээгүй байна. Өөлд угсаатны үүсэл гарал ба өнөөгийн Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын нутгаар тархай бутархай амьдран суугаа өөлд угсаатнуудын түүх, угсаатны зүй, хэл аялгуу, эдийн болоод оюутны соёлын өв болон ойрад аман аялгууны талаар монголын болоод гадаадын хэл шинжлэлч, хэл судлаач эрдэмтэд эрдэм шинжилгээний өгүүлэл төдийгүй ганц сэдэвт бүтээлийн хэмжээнд судалсан судалгаанд өөлд аман аялгууны үгсийг нэлээд дурдсан байгаа ч өөлд аман аялгууны үгсийн санг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судалсан судалгаа өнөөг хүртэл үгүйлэгдсээр байгаа нь энэхүү сэдвээр судалгаа хийх үүдэл санаа болсон билээ.

Иймээс бид монгол хэлний нутгийн аялгууны томоохон бүлэг болох өөлд угсаатнуудын аман аялгууны өвөрмөц онцлогтой үгсийг Өөлд угсаатнуудын оршин сууж байгаа газруудаас сонгож, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, Архангай аймгийн Өлзийт, Өгий нуур сум болон БНХАУ Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр хотын Эвенк Үндэстний Өөртөө Засах Хошууны Имин сум зэрэг газруудад оршин сууж буй өөлд угсаатнуудын аман аялгууныхаа өвөрмөц онцлогоо хадгалан буй үгсийг харьцуулан нутгийн аялгууны судлалд шинэ хэрэглэгдэхүүнийг бий болгохыг зорьсон билээ.

Өөлд аман аялгууны өвөрмөц онцлог бүхий үгс

Бид энэхүү судалгаандаа монгол улсад өөлдийн аман аялгууны талаар голлон судалгаа хийсэн эрдэмтэд болох Д.Бадамдорж, С.Баттулга нарын *Өөлд аман аялгууны ойллого* ганц сэдэвт бүтээлд хавсаргасан 900 гаруй үгтэй *Өөлд аман аялгууны товч толь*, судлаач С.Баттулгын *Өөлдийн аман аялгуу* хэмээх докторын зэрэг горилсон диссертацийн хавсралт болох *Өөлдийн аман аялгууны товч тайлбар толь* (5500 гаруй үгтэй) хэмээх хоёр толь бичгийг гол хэрэглэгдэхүүн болгож, түүнээсээ халх аман аялгуунд хэрэглэгддэггүй өвөрмөц онцлог бүхий 100 үгийг түүвэрлэн авч, Монгол Улсад тархан суурьшсан өөлд угсаатнууд дундаас ойрад аялгууныхаа аман ярианы өвөрмөц үгсийг хэвээр хадгалан буй Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум, халхуудтай хаяа залган амьдран суугаа Архангай аймгийн Өлзийт, Өгийнуур сумын халхажсан өөлдүүд болон БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр хотын Эвенк Үндэстний Өөртөө Засах Хошууны Имин сумын Баянтал, Агуйт, Имин, Билүүт гэх дөрвөн гацаанд голлон тархан суурьшсан өөлд угсаатнуудын оршин сууж байгаа

газар хээрийн шинжилгээ хийж, нийгэм хэл шинжлэлийн аргаар судаллаа. Дээрх хоёр эрдэмтний нэг нь энэ сэдвээр ганц сэдэвт зохиол бичиж докторын зэрэг хамгаалж нөгөө нь мөн адил ганц сэдэвт зохиол бичиж гаргасан учир бид түүвэрлэсэн 100 үгээ “өөлд аялгууны үгс” мөн хэмээн итгэж авсан билээ. Гэхдээ дээрх хоёр эрдэмтний судалгааны зорилго нь хам цагийн үүднээс тухайн үгсийг өөлд аялгуутан хэрхэн хэрэглэж буйг судлах биш, урьд хожид өөрийнхөө цуглуулсан болон холбогдох судалгааны материалуудаас түүж аваад “өөлд аялгууны үгс” гэж ялган тодорхойлсон үгийн сан юм.

Энэхүү судалгаанд хэрэглэгдэхүүн болгон сонгосон 100 үгээс өөр өөр нутаг оронд амьдран суугаа өнөөгийн өөлд угсаатнууд хэдийг нь мэдэж буйг хээрийн судалгааны үр дүнд тодруулан авч үзвэл Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өөлдүүд 84 үгийг, Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуурын өөлдүүд 43 үгийг, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр хотын Эвенк Үндэстний Өөртөө Засах Хошууны Имин сумын Баянтал, Агуйт, Имин, Билүүт гацаанд оршин сууж буй өөлдүүд 61 үгийг тус тус мэдэж байв.

Дээрх тоо баримтаас дүгнэн үзвэл Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өөлдүүд 84 үгийг буюу хамгийн олон үгийг мэдэж байгаа бол БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр хотын Эвенк Үндэстний Өөртөө Засах Хошууны Имин сумын Баянтал, Агуйт, Имин, Билүүт гацаанд оршин сууж буй өөлд угсаатнууд 61 үг, харин Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуурын өөлдүүд 43 үг буюу хамгийн бага хувийг эзэлж байгааг доор хүснэгтлэн үзүүлэв.

Хүснэгт 1. Түүвэрлэн авсан өөлд аман ярианы 100 үгсийг мэдэж буй байдал

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Өөлд угсаатан	Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуур сумын Өөлд угсаатан	Хөлөнбуйр хотын Имин сумын Өөлд угсаатан
64%	25%	11%

Дээрх хүснэгтээс үзэхэд Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өөлдүүд түүхэндээ бусад аялгуутнаас салангид оршин амьдарсаар ирсэн болохлоор тэдний хэл аялгуунд эртний үгс буюу Ойрад аман аялгууны үгс үлэмж ихээр хадгалагдаж байдаг болохоор одоог хүртэл өөлд аман аялгууны үгс бусад газрынхаас илүү их уугуул үгсийн санг хадгалж байна гэж үзэж байна.

Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуур суманд тархан суурьшсан өөлд угсаатнууд олон зуун жил хил залгаа амьдарч байгаагийнхаа хувьд өөлд аман аялгуу нь маш их халхжин өөлд аман аялгууны үгсээ хэрэглэх нь багассан байна.

Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр хотын Эвенк Үндэстний Өөртөө Засах Хошууны дунд хэсэгт Барга, Буриадуудтай хөршилж, Эвенк

үндэстэнтэй ихээр холилдон суурьшсаны үрээр Өвөр Монголын өвөрлөгч аялгууны нөлөөг ихээхэн тусгаж өөлд аман аялгууны өвөрмөц онцлог шинж бүхий үгсээ тодорхой түвшинд алдсан байна гэж бид үзэж байна.

Хүснэгт 2. Өвөрмөц онцлогтой үгсээ хэрэглэж буй буюу авч үлдсэн байдал

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Өөлд угсаатан	Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуур сумын Өөлд угсаатан	Хөлөнбуйр хотын Имин сумын Өөлд угсаатан
48%	21%	31%

Хорьдугаар зууны үед цуглуулсан эх хэрэглэгдэхүүнээс 100 үгээр жишээ авахад 15 хувь нь өөрчлөгдсөн байна. Үүнээс Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд хэрэглэгдэж буй өвөрмөц онцлогтой үгсийн жишээ татвал: **[wulxɛnɛg]** үхрийн ширээр хийсэн усны томхон сав, **[Tögräg]** үхрийн ширээр хийсэн архи, нэрмэл хийх сав, **[arχid]** Айраг исгэдэг үхрийн ширээр хийсэн томоохон уут, **[tsigä]** айраг, **[bambä]** эсгий гудас, **[Agär]** бөмбөлөг, **[hašik]** том хээтэй модон халбага, **[ö kig]** өвлийн дээл, **[xɛɮβ]** тогооны тавиур, **[harem]** тариа будаа буулгах талбай, **[küw]** модон хувин... гэх мэт.

Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуур суманд өөлд аман аялгуу маш ихээр халхажсан учир хэрэглэгдэж буй өвөрмөц онцлогтой үгсийн жишээ татвал: **[haɮβ]** тогооны тавиур, **[taχlä]** намар гарсан ишиг, **[za:mag]** хаврын үед маш бага хэмжээгээр хийдэг үнээний айраг **[hō]** хонгор (адуу малын зүс), **[hondŋ]** ухаа ягаан(адуу малын зүс), **[gass]** гадас, **[mantʃqa:]** манжгаа (лам хүнийг хүндэтгэх хэлбэр) ... гэх мэт.

Үндэсний цөөнх болсон Хөлөнбуйрын өөлдүүдэд хэрэглэгдэж буй өвөрмөц онцлогтой үгсийн жишээ татвал: **[səxu:]** холын аянд авч явдаг төмөр авдар, **[tsas]** овоолж тавьсан түлээ, **[xɛɮβ]** тогооны тавиур, **[ɛirɣ]** ширэг, **[ɛirɣələh]** ширэглэх, **[imnə:ŋ]** имнээн, **[im]** им, **[imnəx]** имнэх, **[æ βæ:]** ээж, **[arxɜlɜx]**... гэх мэт.

Өвөрмөц онцлогтой үгсээ хадгалан үлдсэнээр нь задлан харуулбал Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өөлд хамгийн их буюу 48 хувь, Хөлөнбуйрын Имин сумын өөлдүүд 31 хувь, Архангай аймгийн Өлзийт, Өгийнуур сумын өөлдүүд хамгийн бага буюу 21 хувь мэдэж байгааг дээрх графикаас харж болно.

Гэтэл Эрдэнэбүрэн сумын өөлд угсаатан болон Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуур сумын өөлд угсаатнууд дунд хэрэглэгддэг үгс Хөлөнбуйрын Имин сумын өөлд угсаатнууд дунд хэрэглэгдэхгүй үгс байна. Жишээлбэл: Эрдэнэбүрэн сумын Өөлд **[bagzŋ]** халх. Борлон (Хоёр настай ямаа) Архангайн өөлд. **[bagzŋ]**, **[taχlä]** – намар гарсан ишиг.

Мөн Эрдэнэбүрэн сумын өөлд угсаатан болон Хөлөнбуйрын Имин сумын өөлд угсаатнууд дунд хэрэглэгддэг үгс Архангай аймгийн Өлзийт болон Өгийнуур сумын өөлд угсаатнууд дунд хэрэглэгдэхгүй үгс байна. Жишээлбэл: Хө. Өөлд. [æ βæ:] авай-Халх. [ə:tʃ] ээж гэдэг бол Өлзийтийн өөлдүүд [əmə:] эмээгээ “хөгшин ээж” [øфø:] өвөөгөө “хөгшин аав” гэж дууддаг. Эрдэнэбүрэн сумын өөлд. [ek] ээж гэдэг бол Хөлөнбуйрын өөлдүүд авгынхаа эхнэрийг [aβзгүзŋ] Авга бэргэн “[ə:тə:] ээж, [Aβзгүзŋ]” гэж хоёр янзаар дууддаг.

Эдгээр гурван газарт гурвуулд нь хэрэглэгдэж байгаа үгс мөн байна. Жишээлбэл: Эрдэнэбүрэн сумын өөлд. [širiglīx] ширгэн дээр цог тавьж шатаах зүйл, Хөлөнбуйрын өөлд. Сүнс дуудах дом шившлэгийн үг. Мөн энэ үгээс үүссэн “сүнс дуудах” гэх утгатай [eirəy] ширэг [eiryələh] ширэглэх гэх үйл үг үүсгэсэн байна. Нутгийн хүмүүс сүнс дуудахдаа хүрээндээ галын цог авч дээр нь хуурай будаа, давс зэргийг сацан “ширэг, ширэг, “хүүхдийн толгой нь дээшээ, ширгийн толгой нь доошоо” гэж, хүрээ зөв гурав, буруу гурав эргүүлдэг заншилтай, халх. Нялх хүүхэд ямарваа нэг зүйлээс айж цочсон үед хийдэг домнох Архангайн өөлдүүд [širəv], [širəvləx] зан үйл байдаг. [xələβ] халив- [xələβ] Халх. тогооны тавиур. Өлзийтийн өөлдүүд [haɫβ] гэнэ. Хөлөнбуйрын Өөлд. [imnə:ŋ] имнээн- Халх. [im]им Эрдэнэбүрэн болон Өлзийтийн өөлдүүд адилхан хэлдэг. Үүнээс үйл үг үүсэж имнэх [imnəx] болжээ.

Эдгээрээс зөвхөн Эрдэнэбүрэн сумын өөлд угсаатан дунд хэрэглэж байгаа үгс байна. Жишээлбэл: [wulxəneg] үхрийн ширээр хийсэн усны томхон савыг хэлнэ. [Tögräg] үхрийн ширээр хийсэн архи, нэрмэл хийх сав, [Agār] бөмбөлөг, шаар үүнийг баяр ёслолд өргөн хэрэглэдэг. [hašik] том, хээтэй модон халбага, хийц сайтай, ам халахгүй халбагыг хэлнэ.

Мөн зөвхөн Хөлөнбуйрын Имин сумын Билүүт, Агуйт, Имин, Баянтал гэх дөрвөн гацаанд оршин суудаг өөлд угсаатан дунд хэрэглэгдэж байгаа үгс байна. Жишээлбэл: Хө. Өөлд. [æ βæ:] авай- Халх. [ə:tʃ] ээж ээж гэдэг бол Өлзийтийн өөлдүүд [əmə:] эмээгээ “хөгшин ээж” [øфø:] өвөөгөө “хөгшин аав” гэж дууддаг. Эрдэнэбүрэн сумын өөлд. [ek] ээж гэдэг бол Хөлөнбуйрын өөлдүүд авгынхаа эхнэрийг [aβзгүзŋ] Авга бэргэн “[ə:тə:] ээж, [Aβзгүзŋ]” гэж хоёр янзаар дууддаг байна.

Хуучин өөлд аман аялгууны үгсийн утгын хүрээ нь нэгдмэл байсан бол одоо утга нь салаалсан байна. Жишээлбэл: Хөлөнбуйрын Өөлдүүд [ətʰrəx] этрэх – (хурганы арьс этрэх) Халх. агших, энэ үг нь Эрдэнэбүрэн сумын өөлдүүдийн дунд [etrix], [etix] хөлөөрөө тээх, замдаа авч явах гэсэн өөр утгатай байна. Өөлд. [ku:r] гуур- арьсан бээлий гэх утгаар хэлэгддэг бол Эрдэнэбүрэн сумын өөлдүүд 1.гарын бугуй 2. Үхрийн нурууны арьсан доор үрждэг өт - Халх. Үхрийн нурууны арьсан доор үрждэг өт.

Мөн нөгөө талаас харвал хоёр өөр зүйлийн утга нь явцуураад нэгдэж байна. Жишээлбэл: Хөлөнбуйрын өөлдүүд [laβeɣ] лавшиг - оёж хавсан хөвөнтэй дээлийг ингэж нэрлэдэг байна. Өлзийт болон Өгийнуурын өөлдүүдийн дунд “[laβeɣ] лавшиг” гэдэг нь “тэрлэгэн дээл”- ийг хэлнэ.

Бид энэхүү судалгаандаа түүвэрлэн авсан 100 үгээ хувцас гоёл чимэглэлтэй холбоотой үг хэллэг, ахуйн холбогдолтой үгс буюу сав суулганы холбогдолтой үг хэллэг, амьтны нэр, мал аж ахуйтай холбоотой буюу тоног хэрэгсэлтэй холбоотой үгс, төрөл садны нэр дуудлага болон дуудах нэршилтэй холбоотой үгс гэх мэт төрөл зүйлд ангилан хувааж үзэхэд ахуйн холбогдолтой үгс буюу сав суулганы холбогдолтой үг хэллэг одоогийн өөлд аман аялгуундаа хэрэглэгдсээр байгаа бөгөөд хамгийн их буюу 35 хувийг эзэлж байгаа бол хувцас гоёл чимэглэлтэй холбоотой үг хэллэг 15, мал аж ахуйтай холбоотой буюу тоног хэрэгсэлтэй холбоотой үгс 31, төрөл садны нэр дуудлага болон дуудах нэршилтэй холбоотой үгс 10 тус тус эзэлж байгаа бол амьтны нэр 9 буюу хамгийн бага хувийг эзэлж байна.

Хүснэгт 3. Түүвэрлэн авсан Өөлд аман ярианы үгсийг төрөл зүйлд хуваасан байдал

Ахуйн холбогдолтой үгс буюу сав суулганы холбогдолтой үг хэллэг	Мал аж ахуйтай холбогдолтой буюу тоног хэрэгсэлтэй холбоотой үг хэллэг	Хувцас гоёл чимэглэлтэй холбоотой үг хэллэг	Төрөл садны нэр дуудлага болон дуудах нэршилтэй холбоотой үгс	Амьтны нэр дуудлагатай холбоотой үг хэллэг
35%	31%	15%	10%	9%

Хувцас гоёл чимэглэлтэй холбоотой үгсийн жишээ татвал:

Эрдэнэбүрэн сумын Өөлд. [dewl] Халх. Дээл, [jawšig] Халх. тэрлэг, [ütši] Халх. халх үстэй дээлтэй адил загвартай хэр нь арай өөр өвлийн дээл, [zargig] Халх. сармай илгэн дээл Хөлөнбуйрын өөлдүүд [laβeɣ] лавшиг гэж нэрлэдэг. Гэхдээ ихэнхдээ оёж хавсан хөвөнтэй дээлийг ингэж нэрлэдэг байна. Өлзийт болон Өгийнуурын өөлдүүдийн дунд “Дэвл[dewl]” гэж энгийн халх маягийн дээлийг хэлэх ба “[laβeɣ] лавшиг” гэдэг нь “тэрлэгэн дээлийг” хэлнэ.

Ахуйн холбогдолтой үгс буюу сав суулганы холбогдолтой үг хэллэг:

Өөлд. [wulxəneg] үхрийн ширээр хийсэн усны томхон савыг хэлнэ. Өөлд. [Tögräg] үхрийн ширээр хийсэн архи, нэрмэл хийх сав. Өөлд. [arχid] Архад - Халх. Хөхүүр Айраг исгэдэг үхрийн ширээр хийсэн томоохон уут, Өлзийтийн өөлдүүд ижилхэн хэлдэг. Өөлд. [tšigä] Чигээ- халх. Айраг Эрдэнэбүрэн суманд гүүний саамаар исгэснийг “чигээ” гэж нэрлээд үнээний сүүгээр исгэснийг “айраг” хэмээдэг. Мөн Өлзийт, Өгийнуурын өөлдүүд зэргэлдээ орших халхуудтай уусан гүү барьж сайхан айраг исгэж халх аман аялгууны “айраг” гэх нэршилтэй ижилхэн хэлэгддэг.

Амьтны нэр төрлийн үгс:

[kögildžriḡ] тагтаа, [Hõ] хо-халх. Хонь, [tʃɑrma:χæ:] халх. жараахай, [bɔntʃɔ:] халх. болжмор, [ɑɑ:ltʃ] халх. аалз, [ɑyυ:] халх. баавгай, [bu:tʃvɑ:] халх. бууран тайлаг, [dɔkʃɛ:] халх. хөх дэглий шувуу... гэх мэт.

Мал аж ахуйтай холбоотой буюу тоног хэрэгсэлтэй холбоотой үгс:

Өөлд. [bə:m] Бөөм халх. 1.бугуйл 2.малын ходоодонд бөөгнөрсөн хялгас, ноос. Өөлд. [bə:m] [ɑrgūmdz] Бөөмий аргамж- Халх.Бугуйл- Морь малыг хүзүүгээр нь оосорлон татаж барих урт сур (Сураар гөрсөн гөрмөл бугуйл ч байдаг) Хөлөнбуйрын Өөлд. [imnə:ŋ] имнээн- Халх. [im]им Эрдэнэбүрэн болон Өлзийтийн өөлдүүд адилхан хэлдэг. Үүнээс үйл үг үүсэж имнэх[imnəx] болжээ.

Төрөл садны нэр дуудлага болон дуудах нэршилтэй холбоотой үгс:

Хө. Өөлд. [æ βæ:] авай- Халх. [ə:tʃ] ээж гэдэг бол Өлзийтийн өөлдүүд [эмə:] эмээгээ “хөгшин ээж” [өфө:] өвөөгөө “хөгшин аав” гэж дууддаг. Эрдэнэбүрэн сумын өөлд. [ek] ээж гэдэг бол Хөлөнбуйрын өөлдүүд авгынхаа эхнэрийг [аβзгүзŋ] Авга бэргэн “ [ə:тə:] ээж, [Аβзгүзŋ]” гэж хоёр янзаар дууддаг. Архангайн Өөлд. [ɑ:tʃɑ:]аажаа-эгч гэх мэт.

Дүгнэлт

Өөлдийн угсаатны зүй, хэл аялгуу, эдийн болон оюуны соёлын өв болон ойрад аман аялгууны талаар монголын болоод гадаадын эрдэмтэд судлан шинжилж бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт бүтээлүүдэд өөлд аман аялгууны үгс их бага хэмжээгээр дурдагдаж байсан хэдий ч өөлд аман аялгууны судалгааг дагнан хийсэн эрдэмтэн Д.Бадамдорж, С.Баттулга нар “өөлд үгс” хэмээн ялган тэмдэглэсэн үгсийн жагсаалт гаргасныг энд онцлууштай.

Гэтэл хам цагийн үүднээс дээрх үгсийг хэрхэн хэрэглэж буйг нийгэм хэл шинжлэлийн талаас судлан үзэхэд, нэг үгийг гурван өөр газар ижилхэн хэрэглэж байгаа, нэг үгийг хоёр газарт хэрэглэгдэж байхад зарим үгийг зөвхөн нэг газарт хэрэглэж байгаа, хуучин үгсийн утгын хүрээ нь нэгдмэл байсан бол одоо утга нь салаалж байгаа, хоёр өөр зүйлийн утга нь явцуураад нэгдэж байгаа зэргээр харилцан адилгүй хэрэглэж буйг илрүүлэн судлав.

Сонгосон үгсийг зүйлчилсэн утгаар нь авч үзвэл өөр хоорондоо харилцан адилгүй хэрэглэдэг хамгийн их солигдсон үгс нь амьтны нэр төрлийн үгс байгаа бол гурван өөр газарт нийтлэг хэрэглэж буй уугуул шинжээ сайн хадгалж байгаа үгс нь ахуйн холбогдолтой үгс буюу сав суулганы нэршилтэй холбогдолтой үгс байна. Үүний шалтгаан нь гурван өөр газар амьдран суугаа өөлдүүдийн нийгмийн өдөр

тутмын аж амьдралтай нягт холбоотой үг хэллэг хамгийн ихээр уугуул аялгууныхаа үгсийн сангийн шинжийг хадгалж байна хэмээн дүгнэж байна.

Research on the Words of the Local Mongolian Dialect From a Sociolinguistic Point of View

(On the Example of the Uuld (ethnic) Oral Dialect)

Erdenesuren Tumen-Ochir

*Master student at the School of Mongolian Studies, Inner Mongolia University
Hohhot, China*

Abstract: This paper employs sociolinguistic methodologies to investigate the distinctive lexical elements within the ööld ethnic groups dispersed across Mongolia as well as Inner Mongolia in People's Republic of China. Specifically, the study focuses on the ööld communities in various regions, including the Erdenebüren soum of Khovd province and the Ölziit and Ögiinuur soums of Arkhangai Province in Mongolia, as well as the Imin, Bayantal, Aguit, and Bilüüt villages of Imin soum in Inner Mongolia's Autonomous Prefecture of Hölunbuir, China, predominantly inhabited by ööld groups.

The research findings reveal that the utilization of unique ööld dialectal terms varies significantly based on diverse sociocultural factors. These factors encompass distinct geographical locations, socioeconomic class, societal roles, occupational domains, social standing, age brackets, gender dynamics, and the specific interpersonal context in which communication occurs.

This study concludes that the presence and usage of ööld-specific vocabulary are intricately linked to the intricate social fabric and contextual intricacies shaping the linguistic expressions within Ööld ethnic groups across different settings and circumstances.

Keywords: Uuld oral dialect words, Oirad oral dialect words, distinctive words

Ном зүй

- Бадамдорж, Д., Баттулга, С. (2005). *Өөлд аман аялгууны ойллого*. Улаанбаатар: Экимто ХХК.
- Баттулга, С. (2009). *Өөлдүүд, тэдний аман аялгууны тухай. Өөлдийн түүх, соёлын цуврал I*, 76-82, Улаанбаатар: Экимто ХХК.
- Баттулга, С. (2019). *Өөлдийн аман аялгуу*. Улаанбаатар: Бэмби сан ХХК.
- Батзаяа, Г., Батдорж, Ц., Баярчимэг, Э. (2022). *Монгол хэл судлал нутгийн аялгуу*. Улаанбаатар: Соёмбо Принтинг ХХК.

- Лүнт (1994). *Ойрад нутгийн аялгууны үгсийн хураангуй*. Хөххот: Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо.
- Боржигон Баярмэнд (1994). *Монгол хэлний нутгийн аялгуун дахь өвөрмөц үгсийн судлал*. Хөххот: Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо.
- Чамхад Режмэ (2008). *Иминий Өөлдүүд*. Хөххот: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.
- Владимирцов, Б.Я. (1929). *Монгол бичгийн хэл ба халх аялгууны харьцуулсан хэлзүй: удиртгал ба авиа зүй*. {Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия: Введение и фонетика}. Ленинград хот.
- Санжаа, Ж. (2004). Архангай аймгийн Өлзийт сумын халхажсан өөлдийн аман аялгуу. *Чой.Лувсанжавын нэрэмжит ХИДС-ийн “Эрдэм шинжилгээний бичиг*. 3, 26-38.
- Гэрэлт, П. (2009). Хөлөнбуйрын өөлдийн газар нутаг ба хүн амын хувиралт. *Өөлдийн түүх, соёлын цуврал I*, 65-72.
- Урьхан., Бадма-Одсэр (2020). *Хөлөнбуйрын Өөлд Монголчуудын хэл яриан дахь өвөрмөц үгс*. Улаанбаатар.
- Үндэсний статистикийн хорооны цахим сан: <https://nso.mn/mn>